




# МОНГОЛ УЛС ДАХЬ БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖИЛ

Г.Баянзул  
Д.Нямсүрэн  
У.Мягмаржав  
Ж.Нарантуяа  
Б.Жавзандулам

## NORRAG — БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

NORRAG бол боловсрол, сургалтын хамтын ажиллагаа ба олон улсын бодлогын чиглэлээр ажилладаг, дэлхий даяар гишүүнчлэлд суурилсан сүлжээ юм. 1977 онд Судалгааны Хэлэлцүүлэг ба Зөвлөлдөх Баг (CX35) байгуулагдаж, дараа нь бүс нутгийн хэд хэдэн CX35-ийг үүсгэн байгуулсан бөгөөд тэдгээрийн нэг нь 1986 онд NORRAG байгууллага болж хөгжсөн. NORRAG-ийн үндсэн үүрэг, давуу тал нь үнэ цэнтэй мэдлэгийг бүтээж түгээх, зуучлахын зэрэгцээ боловсролын бодлого, практик үйл ажиллагааг тодорхойлж хэрэгжүүлдэг Засгийн газар, их сургуулиуд, ТББ-ууд, олон улсын байгууллага, сангууд, хувийн хэвшлийн зэрэг байгууллагуудтай хамтран үндэсний болон олон улсын түвшинд чадавхыг нь бэхжүүлэх явдал юм. Ингэснээр NORRAG нь боловсрол, сургалтын тэгш хүртээмж, чанарыг сайжруулах чиглэлээр илүү оролцоог хангасан, нөтөлгөөнд суурилсан шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг.

NORRAG Даян дэлхийн Боловсролын Төв нь Женевийн Төгсөлтийн дараах сургуульд харьяалагддаг ба Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА)-ын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. NORRAG байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ болон бусад мэдээлэлтэй [www.norrag.org](http://www.norrag.org) вэб хуудсаар орж танилцах боломжтой.



@norrag



norrag.network



vimeo.com/norrag

## KIX EMAP — БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

Боловсролын төлөөх дэлхийн түншлэл (GPE)-ийн Мэдлэг Инновацийн Солилцоо (KIX) нь Олон улсын хөгжлийн судалгааны төв (IDRC) -тэй хамтран ажиллаж, GPE байгууллагын түнш орнуудад боловсролын хүчирхэг тогтолцоог бий болгох, тогтвортой хөгжлийн 4-р зорилгод хүрэх ахиц дэвшлийг хурдасгах зэрэгт дэмжлэг үзүүлж туршлага, инноваци, мэдлэгийг холбох зорилготой билээ. Дэлхий даяар дөрвөн KIX төв буюу бүсийн суралцахуйн түншүүд IDRC байгууллагын удирдлага дор ажилладаг ба KIX-ийн хүрээнд бүс нутгийн форумын үүрэг гүйцэтгэдэг. NORRAG бол KIX Европ, Ойрхи Дорнод, Хойд Африк, Ази, Номхон далайн (EMAP) төвийг (хуучнаар KIX EAP төв) хариуцсан бүсийн суралцахуйн түнш байгууллага юм.

KIX EMAP байгууллага нь Европ, Ойрхи Дорнод, Хойд Африк, Ази, Номхон далайн бүс нутагт Номхон далайн арлын 9 улс зэрэг GPE-ийн түнш 30 гаруй орны үндэсний боловсролд оролцогч талуудын хооронд улс дамнасан мэдлэг, инновацийн солилцоо ба ашиглалт, суралцахуй, шинэ санаачлага, хамтын ажиллагааг идэвхжүүлэн ажилладаг юм. Мөн тус байгууллага нь боловсролын салбарт ажиллагсдад мэргэжил дээшлүүлэх, улс хоорондын айлчлал хийх замаар хамтран суралцах, солилцооны хөтөлбөрүүдэд оролцох боломж олгодог.



@KIXEMAP



gpekix.org/regional-hub/kix-emap



norrag.org/kix-emap




KIXEMAP



@KIXEMAP

## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БОЛОВСРОЛ БА ХӨГЖЛИЙН САН (FIT-ED) БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

Филиппин улсад байгуулагдсан ашгийн бус байгууллага болох Инновацийн Технологийн Боловсролын Сан нь боловсролын хувирган өөрчлөлт, бүх нийтийн боловсрол, судалгаа ба бодлогын нөлөөлөл гэсэн гурван үндсэн хөтөлбөрт тулгуурлан сургалтын чанар, эрх тэгш байдлыг дэмжин ажилладаг. FIT-ED нь эрх тэгш, хүртээмжтэй, тэгш хамарсан ертөнцийг бий болгохын тулд Филиппин болон бусад хөгжиж буй орнуудын ард иргэд, олон нийтэд суралцах, шинийг санаачлахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилготой.



fit-ed.org

## TPD@SCALE ЭВСЭЛ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

Төрийн байгууллагууд, олон улсын хөгжлийн агентлагууд, төрийн бус байгууллагууд, их дээд сургуулиуд, судалгаа ба бодлогын төвүүд болон багшийн мэргэжлийн хөгжилд (БМХ) оролцдог бусад боловсрол, технологийн чиглэлийн оролцогч талуудын хамтын хүчин чармайлтын үр дүнд бий болсон TPD@Scale эвсэл нь хамтын ажиллагаа, судалгаа, хэрэгжилтийн дэмжлэг үзүүлж эрх тэгш, чанартай, тогтвортой, далайцтай, МХТ-д суурилсан БМХ-ийг хөхиүлэн дэмжих замаар хүн бүрт тэгш хамарсан, чанартай боловсролыг олгож насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлэх – Тогтвортой Хөгжлийн 4-р Зорилт (ТХЗ) -д хүрэхэд жинтэй хувь нэмэр оруулахыг зорьж ажилладаг.



tpdscalecoalition.org

## KIX EMAP МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙН СУРГАЛТУУДЫН ТУХАЙ

KIX EMAP мэргэжлийн хөгжлийн сургалт нь Европ, Ойрхи Дорнод, Хойд Африк, Ази, Номхон далайн бүс нутагт оршдог GPE-ийн түнш 30 гаруй орны үндэсний боловсролын экспертүүдэд зориулагдсан мэргэжил дээшлүүлэх сургалтууд юм. Үндэсний хэмжээний судлаачид, мэргэжилтнүүдээс бүрдсэн багууд инноваци, бодлогын дүн шинжилгээ хийж нөхцөл байдлыг судлан хамтдаа шинэ мэдлэг бүтээдэг. Эдгээр мэргэжил дээшлүүлэх сургалтууд нь оролцогчдод туршлагаа солилцох, мэдлэгээ хуваалцах, үндэсний боловсролын тогтолцоогоо бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах боломжийг олгож байна. Түүнчлэн мэргэжлийн хөгжлийн сургалтууд нь үндэсний экспертүүдийн хувьд судалгааны үр дүнгээ олон улсад хэвлэн нийтлэх, KIX EMAP төвийн дэмжлэгтэйгээр төрөл бүрийн онлайн платформ дээр хийсэн зүйлээ танилцуулж түгээх дэмжлэгийн хэрэгсэл юм.

## БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ (TPD@SCALE) МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТУХАЙ

Энэхүү кейс судалгаа нь KIX EMAP “Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих (TPD@Scale)” мэргэжил дээшлүүлэх сургалтын үр дүнд бичигдсэн болно. Мэдээллийн технологийн боловсрол ба хөгжлийн сан (FIT-ED)-аар дамжуулан хөгжиж буй орнуудыг дэмжин ажиллаж буй TPD@Scale Эвслийн зүгээс энэ сургалтыг 2022 оны 9-р сарын 23-наас 12-р сарын 16-ны хооронд зохион байгуулсан. Сургалтад оролцогчид 11 долоо хоногийн турш, сурагчдын сурлагын амжилтыг дээшлүүлэхэд багш нарыг чадавхжуулах, хөгжүүлэх тухайд мэдээлэл, харилцааны технологид суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрхэн нутагшуулах, өргөжүүлэн хөгжүүлэх талаар судаллаа. Балба, Бангладеш, Бутан, Гүрж, Киргизстан, Мальдив, Молдав, Монгол, Судан, Тажикстан, Узбекистан, Вьетнам, Йемен зэрэг 13 улсын үндэсний мэргэжилтнүүдийн багууд энэхүү сургалтад хамрагдав.



KIX EMAP мэргэжлийн хөгжлийн сургалтын кейс судалгаа, 2024/05



нь KIX EMAP төвд дэмжлэг үзүүлдэг.



Canada



Network for international policies and cooperation in education and training

Фото зургийг

Khasar Sandag-World Bank/Flickr

Creative Commons licence: Attribution-NonCommercial 4.0 International (CC BY-NC 4.0)-ийн болзол нөхцлийн дагуу хэвлэн нийтлэв.



Холбогдох лиценз, зөвшөөрлийн тухай асууж лавлах зүйл байвал дараах хаягаар хандана уу:

KIX EMAP Hub / NORRAG

20, Rue Rothschild

P.O. Box 1672 1211 Geneva 1

Switzerland

[norrag.kix@graduateinstitute.ch](mailto:norrag.kix@graduateinstitute.ch)

Энэхүү кейс судалгаа нь гадны дэмжлэгтэйгээр KIX EMAP “Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих (TPD@Scale)” мэргэжил дээшлүүлэх сургалтын үр дүнд, Канадулсын Олон улсын хөгжлийн судалгааны төв (IDRC) -тэй хамтарсан Боловсролын төлөөх дэлхийн түншлэл (GPE)-ийн Мэдлэг Инновацийн Солилцоо (KIX)-ны дэмжлэгтэйгээр бүтээгдсэн. Судалгааны үр дүн, тайлбар, дүгнэлтүүд нь KIX EMAP байгууллага, NORRAG, GPE ба түүний удирдах зөвлөл, эсвэл Монгол улсын Засгийн газрын үзэл хандлага, бодол санааг илэрхийлээгүй болно.

KIX EMAP байгууллага / NORRAG энэхүү өгүүлэлд дурдагдсан өгөгдөл, тоон мэдээний үнэн зөв байгаа эсэхэд баталгаа гаргахгүй.

## ЗОХИОГЧДЫН ТУХАЙ

**Гунгаагийн Баянзул** нь “Од ур чадвар” ТББ-ын УЗ-ийн гишүүн бөгөөд БСҮХ-д Бүх нийтийн англи хэлний хөтөлбөрийн менежерээр ажилладаг. Тэрбээр ЕБС-д 10 гаруй жил багш, сургалтын менежерээр ажиллахын зэрэгцээ сургалтын хөтөлбөр боловсруулах, сурах бичиг зохиох болон багшийн мэргэжил дээшлүүлэх чиглэлийн төслүүдэд оролцож байсан. Баянзул Австралийн Квинслендийн ИС-д хэл шинжлэл, Их Британий Хаддерсфильдийн ИС-д боловсролын удирдлагаар тус тус мастерийн зэрэг хамгаалсан бөгөөд Монгол улс дахь багшийн чадамжийн хүрээ, багшийн мэргэжлийн стандартын талаарх үндэсний нөхцөл байдлын анализ хийх багт ажилласан. Сүүлийн үед багшийн мэргэжлийн хөгжлийн чиглэлээр судалгаа, арга зүйн ажил хийж байна.

**Даваасүрэнгийн Нямсүрэн** нь БЕГ-ын газарзүйн багшийн хөгжил хариуцсан мэргэжилтэн юм. Тэрбээр БМДИ-д \хуучнаар\ 5 жил ажилласан туршлагатай бөгөөд өдгөө БЕГ-т үндэсний хэмжээнд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтууд зохион байгуулан ажилладаг. Нямсүрэн 2019 онд Улаанбаатарын Олон улсын их сургуульд “ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулах нь” сэдвээр мастерын зэрэг хамгаалсан. Багшийн хөгжлийн бодлого, мэргэжил дээшлүүлэх чиглэл, үе шатуудын талаар судалгаа хийж ажилладаг мэргэжилтэн юм.

**Усны-Эхийн Мягмаржав** нь Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Дээд боловсролын сургалтын хөтөлбөр, үнэлгээ хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан юм. Тэрээр МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуульд биологийн багш, улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газарт мэргэжилтнээр ажиллаж байсан бөгөөд 2013 оноос БСҮХ-д сурах бичиг, сургалтын орчин хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан, секторын эрхлэгчээр ажиллаж, 2016 оноос эхлэн дээд боловсролын сургалтын хөтөлбөр, үнэлгээний чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээ, арга зүйн ажил хийж байна. У.Мягмаржав нь боловсролын салбарт 4 ном, сурах бичиг, гарын авлага хамтран зохиосноос гадна нийт 29 ном, сурах бичиг, гарын авлагын агуулга, техникийн редактороор ажиллажээ. Тэрээр 47 эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, эрдэм шинжилгээний бага хуралд 21 удаа илтгэл тавьж, 23 төсөл дээр хамтран ажилласан.

**Жамцын Нарантуяа** (PhD) нь БШУЯ-ны Бодлогын нэгдсэн төлөвлөлтийн газарт шинжээчээр ажиллаж байна. Тэрбээр боловсролын менежмент, хүний нөөц, жендэр, сурах бичиг зэрэг чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийдэг ба 2023 онд батлагдсан Боловсролын багц хууль болон холбогдох журмуудыг боловсруулахад гар бие оролцон ажилласан судлаач юм. Нарантуяа АХБ, ЮНЕСКО, ЮНИСЕФ зэрэг гадаад дотоодын байгууллагуудын боловсролын чиглэлээр хэрэгжүүлдэг төслүүдэд төслийн зөвлөхөөр ажилладаг.

**Батсайханы Жавзандулам** (PhD) нь Монгол улсын боловсролын их сургуульд 2010 оноос хойш багшилж байгаа бөгөөд тус сургуулийн Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн Арга зүйн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна. Тэрээр баклаврын болон ахисан түвшний сургалтын хүрээнд “Үйлийн судалгаа”, “Судалгааны арга зүй”, “Боловсролын чанарын судалгааны арга зүй”, “Судалгааны арга зүйн парадигм ба асуудал” зэрэг хичээлийг төлөвлөж, зохион байгуулахын зэрэгцээ боловсролын салбарт тулгамдаж буй асуудалд чиглэсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийдэг судлаач юм.

---

# АГУУЛГА

---

Товчилсон үгсийн жагсаалт	6
Талархал	7
Бодлогын зөвлөмж	8
Ерөнхий мэдээлэл	8
Монгол Улс дахь багшийн мэргэжлийн хөгжлийн тогтолцоо	9
Багшийн мэргэжлийн хөгжилд тулгараад буй асуудал, сорилт бэрхшээл	12
Санал болгож буй бодлого, шийдлүүд	14
Багшийн мэргэжлийн хөгжлийн тогтолцоог үндэсний хэмжээнд хөгжүүлэх, боловсронгуй болгох асуудалд	17
Ашигласан материалууд	16
Зураг	
Зураг 1. Монгол улс дахь багшийн мэргэжлийн хөгжлийн сургалтын бүтэц	8

---

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

---

БАБХГ	Багш ажилтан, байгууллагын хөгжлийн газар
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БМТТ	Боловсролын мэдээллийн технологийн төв
БСҮХ	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ДБ	Дэлхийн банк
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
КБтТ	Кембрижийн Боловсролын төлөөх Түншлэл
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУЗГ	Монгол улсын засгийн газар
МХБ	Мэргэжлийн хөгжлийн бүлэг
НБГ	Нийслэлийн боловсролын газар
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага
ЮНИСЕФ	НҮБ-ын Хүүхдийн Сан

---

## ТАЛАРХАЛ

---

Манай багийн гишүүдэд багшийн мэргэжлийн хөгжлийг хэрхэн дэмжих талаар онол, практик хосолсон цахим сургалтад хамрагдах боломж олгож энэхүү тойм судалгааны нийтлэлийг бичихэд дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгсөн KIX-EMAP болон NORRAG байгууллагын хамт олонд талархал илэрхийлж байна.

# БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

## Ерөнхий мэдээлэл

2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас “Алсын хараа-2050” хэмээх Монгол Улсын урт хугацааны, цоо шинэ хөгжлийн бодлогыг баталж нийгмийн хөгжлийн стратегийг илүү иргэн төвтэй байхаар тодорхойлсон юм. Тус бодлогын баримт бичгийн 2.1-т Засгийн газраас хүн бүрд чанартай боловсролээзмшихтэгшболомжбүрдүүлж,боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орныхөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ гэж заажээ (УИХ, 2020б). Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төрөөс боловсролын салбар дахь хүний нөөцийн цогц бодлогыг хэрэгжүүлэх, мэргэжлийн хөгжлийн тогтолцоог бүрдүүлж мерит буюу чадахуйн зарчимд үндэслэн боловсон хүчний сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, салбарын хүрээнд жендерийн тэгш байдлыг хангах, хөдөө орон нутаг болон алслагдсан бүсийн боловсролын салбарын албан хаагчдыг орон сууцаар хангах зэрэг нэлээд чухал арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Боловсролын ерөнхий хуулийг олон талын оролцоотойгоор удаан хугацаанд хэлэлцэж, шинэчлэн боловсруулсны эцэст Монгол Улсын Их Хурал 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд тус хуульд зааснаар Монгол улсад албан боловсрол нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техник боловсрол, дээд боловсрол гэсэн 4 түвшинтэй байна. Манай улсын боловсролын салбарт шат дараалсан реформ, шинэчлэлүүд хийгдэж ихээхэн ахиц дэвшил, эерэг үр нөлөө авчирсан хэдий ч хүн амын шилжилт хөдөлгөөн ихсэх, чанарын удирдлагын асуудал, эрх тэгш байдлыг хангахад ахиц гарахгүй байх, багшийн хөгжлийн тууштай бодлого үгүйлэгдэж байгаа зэрэг томоохон сорилтууд боловсролын тогтолцоонд тулгарсаар байна. Монгол улсын орчин цагийн багшийн хөгжлийн бодлого 4 өөр үе шатыг туулж ирсэн бөгөөд үүнд 1-р үе шат буюу 1990-1995 он өмнөх тогтолцооны задралын үе, 2-р үе шат буюу 1995-2006 он Засгийн газраас боловсролын шинэ тогтолцоог дэмжсэн багшийн мэргэжлийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөлтийн үе, 3-р үе шат буюу

2007-2011 он конструктив онолын зарчмууд болон цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай багшлахуйн эрх зүйн шинэ орчныг бүрдүүлсэн үе, 4-р үе шат буюу 2012-2018 онд багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих бие даасан, институтчлагдсан тогтолцоо сэргэсэн үе тус тус хамаарна (ЮНЕСКО, 2020).

Тухайлбал, 2007 онд багшийн ажлын норм тогтоох, цалин хөлсийг тооцож олгох, нөхөн олговор, нэмэгдэл урамшууллыг журамлан баталж (БШУЯ, 2007), 2008-2015 онд Засгийн газраас цэцэрлэг, ЕБС-ийн бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлсэн байна (МУ-ын Засгийн газар, 2008). 2018 онд БСШУС (Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын) сайдын А/195 дугаар тушаалаар батлагдсан журмаар багшийн мэргэжлээр баклаврын зэрэг эзэмших хөтөлбөрт их, дээд сургуульд оюутан элсүүлэх ерөнхий шалгалтын босго оноог шинэчлэн тогтоосон (БШУЯ, 2018). Ийнхүү 2000 оноос хойш боловсролын салбарын эрх зүйн орчинг сайжруулах хүрээнд 365 гаруй дүрэм журам, тушаал шийдвэр, зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оржээ (БЕГ, 2023в). Эдгээр бодлогын шинэчлэлүүд нь Монгол Улс дахь багшийн мэргэжлийн хувьсан хөгжиж ирсэн үе шатуудыг илэрхийлж байгаа боловч өөр хоорондоо авцалдахгүй төрөл бүрийн хөтөлбөрүүд, хууль эрх зүйн актууд, тогтоол, тушаал журмууд хэрэгжиж улмаар хуваагдмал нөхцөл байдлыг үүсгэж байгаа нь чанарын шинэчлэл хийх түвшинд багшийн хөгжлийг тодорхойлох нэгдмэл бодлоготой байхыг улам бүр шаардаж байна.

Монгол Улсад багшаар ажиллахад их, дээд сургуульд суралцаж багшийн мэргэжил эзэмшсэн байх шаардлага тавьдаг. Харин шинээр батлагдсан Боловсролын ерөнхий хуульд зааснаар багшаас өөр мэргэжил эзэмшсэн Монгол Улсын иргэн багш бэлтгэх хувилбарт сургалтад хамрагдан багшийн мэргэжлээр ажиллах боломжтой болсон (УИХ, 2023). 2022-2023 оны хичээлийн жилд Монгол улсын хэмжээнд 2,418 боловсролын байгууллагад 52,989 багш, ажилтан ажиллаж байгаагаас ерөнхий боловсролын сургуульд 36,118 багш ажиллаж байна. Улсын хэмжээнд нийт 859 сургуульд эдгээр



ерөнхий боловсролын сургуулийн багш нар ажиллаж байгаа бөгөөд бараг 4 сургууль тутмын нэг (23,1%) нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг гэсэн тоон мэдээлэл бий (БШУЯ, 2023в). Монгол улсын нийт хүн ам 3,504,741-д хүрсэн (ҮСГ, 2023) ба нийт хүн амын 1/3 нь буюу 1,195,600 хүн аль нэг шатны боловсролын байгууллагад суралцаж, боловсрол эзэмшиж байна.

2012-2019 онд БМДИ Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяанд үйл ажиллагаа явуулж үндэсний хэмжээнд багшийн мэргэжлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж мэргэжлийн хөгжлийн сургалтуудыг хариуцан зохион байгуулж байв. БМДИ-ээс ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан багшийн мэргэжлийн хөгжлийн сургалтуудыг танхимын хэлбэрээр удирдан явуулдаг байсан ба Ковид-19 цар тахал эхэлснээс хойш дээрх сургалтуудыг цахим хэлбэрт шилжүүлэн зохион байгуулж эхэлжээ.

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 12 дугаар сард БМДИ-ийг татан буулгаж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох БЕГ-ыг үүсгэн байгуулах шийдвэр гаргасан (МУ-ын Засгийн газар, 2021). Одоогийн байдлаар БЕГ нь 8 газартай, нийт 145 ажилтан, албан хаагчтай (БЕГ, 2022) бөгөөд Багш, ажилтны болон байгууллагын хөгжлийг хариуцсан нэгж (БАБХГ)-ээс Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйл, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтыг үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулж байна (УИХ, 2018). БЕГ, БҮТ, БМТТ, БСҮХ зэрэг байгууллагууд нь Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яаманд шууд харьяалагддаг, боловсролын мэргэжлийн байгууллагууд юм.

Монгол Улс дахь багшийн мэргэжлийн хөгжлийн тогтолцоо

Монгол Улсын багшийн мэргэжлийн хөгжлийн төвлөрсөн тогтолцоо нь ЕБС болон СӨББ-ын удирдлагууд, багш, менежерүүдэд зориулсан мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт ба модуль сургалтуудаас бүрддэг.

Зураг 1. Монгол улсад хэрэгжиж буй багшийн мэргэжлийн хөгжлийн сургалт, үйл ажиллагааны бүтэц

1	Үндсэн сургалт	
2	Модуль сургалт	2а. Зорилтот сургалт
		2b Сонголтот сургалт
2а.	Зорилтот сургалт	заавал судлах
		сонгон судлах

Эх сурвалж: Боловсролын ерөнхий газар

Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт нь ерөнхий боловсролын ба сургуулийн өмнөх боловсролын байгууллагад эхний жилдээ, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш, багш бус ажилтнуудад зориулагдсан бөгөөд багш нар 5 жил тутамд цахим, танхим хосолсон хэлбэрээр, 1 сарын хугацаанд 48 цагийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагддаг. БЕГ-ын багшийн хөгжил хариуцсан мэргэжилтнүүд үндсэн сургалт явуулахад хамтран ажиллах багийг сонгож сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсруулах зэргээр тус сургалтыг хамтран зохион байгуулж байна. Төрөөс мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын зардлыг санхүүжүүлэх зохицуулалтын хүрээнд БЕГ сургагч багшийн ажлын хөлс, сургалтад оролцогчдын тээврийн зардал болон бусад зардлыг хариуцан төлдөг. 2019-2020 оны хичээлийн жилд үндсэн сургалтад 5,510 хүн бүртгүүлснээс 4,787 багш, ажилтан хамрагдан мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна (БЕГ, 2019).

МУЗГ-ын 91 дүгээр тогтоол (МУ-ын Засгийн газар, 2022), Сайдын 170 дугаар тушаалын дагуу (БШУЯ, 2022) жил бүр боловсролын байгууллагын нийт багш, ажилтнуудад зориулсан модуль сургалтуудыг цахим хэлбэрээр зохион байгуулж байна. Модуль сургалтууд нь зорилтот ба сонголтот гэсэн 2 түвшинтэй. Багш нарын хувьд мэргэжлийн тусгай ур чадвар олгох, хувь хүний хөгжлийг дэмжих чиглэл бүхий сонголтот модуль сургалтаас чөлөөтэй сонгон суралцаж нэг кредит цаг цуглуулах боломжтой. Зорилтот модуль сургалт нь заавал судлах ба сонгон судлах гэсэн бүтэцтэй байна. БЕГ-аас цахим модуль сургалтын удирдамж, сэдэв, тавигдах шаардлагыг олон нийтэд нээлттэй зарлаж сургалт зохион байгуулах багуудыг сонгон шалгаруулж (БЕГ, 2023а), их дээд сургууль, ТББ зэрэг янз бүрийн сургалтын байгууллагуудтай хамтран ажилладаг. 2023-2024 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх, бага, дунд сургуулийн багш, удирдах ажилтнуудад зориулсан 154 модуль сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн байна (БЕГ, 2023б). БЕГ-ын дэргэд Боловсролын Магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (БМИҮЗ), БШУЯ, БСҮХ болон бусад байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн 60 эксперт, мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй модуль сургалтын багийг сонгон шалгаруулах зөвлөлийг байгуулжээ. Энэхүү зөвлөл модуль сургалт зохион байгуулах сонирхлоо илэрхийлсэн 230 багийн өргөдөл, хүсэлтийг тавигдах шаардлагын дагуу хянасны үндсэн дээр шаардлагыг бүрэн хангасан 154 сургалтыг сонгон шалгаруулсан гэв. Холбогдох журмын дагуу багш бүр жилд 1-2 удаа багшийн мэргэжлийн хөгжлийн 2 (заавал судлах ба сонгон судлах) модуль сургалтад хамрагдах үүрэгтэй бөгөөд төрөөс улсын сургуулиудад мэргэжил дээшлүүлэх сургалтын санхүүжилтийг шууд олгодог. Багшийн өөрөө сонгох болон заавал судлах модуль сургалтын зардлыг энэхүү санхүүжилтийн хүрээнд сургуулиуд хариуцан шийдвэрлэх боломжтой болсон юм.



Дээрх 154 модуль сургалтын 113 нь багш удирдсан, зорилтот модуль сургалт байсан ба ЕБС-ийн улирлын амралтаар буюу 2024 оны 1 дүгээр сард зохион байгуулагдсан. Түвшинчилсэн модуль сургалтын тухайд, багшийн ажлын гүйцэтгэлийн индексээр 5 болон 6 дугаар түвшинд орсон багш нар заавал судлах модуль сургалтад хамрагдах шаардлагатай байдаг бол 1-4 дүгээр түвшинд үнэлэгдсэн багш нар сонгон судлах модуль сургалтад хамрагддаг. БЕГ-аас өгсөн албан ёсны мэдээллээр 2023 онд нийт багш нарын бараг тал нь 5, 6-р түвшинд үнэлэгдсэн гэжээ (БШУЯ, 2023б). Багшийн ажлын гүйцэтгэлийн индексийн талаар багшийн мэргэжлийн хөгжлийн төсөв гэсэн хэсэгт нэмж тайлбар оруулав.

Үлдсэн 41 сургалт нь бие даан судлах боломжтой, сонголтот модуль сургалт байсан бөгөөд мөн 1 дүгээр сард зохион байгуулагдсан. Өөрсдийн хувь хүний хөгжлийн болон мэргэжлийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад үндэслэн 40,000 багш, сурган хүмүүжүүлэгч дээрх модуль сургалтуудад хамрагдах боломжтой ажээ. Нэг сонголтот эсвэл зорилтот модуль сургалтыг 1,000 хүртэлх оролцогч цахимаар нэгэн зэрэг сонгон суралцах боломжтой.

Багшийн мэргэжлийн хөгжлийн модуль сургалт зохион байгуулдаг голлох байгууллагуудад:

- Монгол Улсын Их Сургууль, МУБИС, Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Соёл Урлагийн Их Сургууль, Этүгэн Их Сургууль, Отгонтэнгэр Их Сургууль, Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль, Мандах Их Сургууль болон бусад их сургуулиуд, ерөнхий боловсролын сургуулиуд;
- Монгол улсын Шинжлэх ухааны академи, Удирдлагын академи, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, БМТТ, НБГ, БҮТ, БСҮХ;
- Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Боловсролын шинжлэх ухааны академи, Тэгш таван ухаан, Боловсролд тэгш боломж болон бусад ТББ-ууд, цэцэрлэг, сургууль, компани гэх мэт хувийн хэвшлийн байгууллагууд;
- Бие даасан сургалтын багууд зэрэг орно.

#### **Багшийн мэргэжлийн хөгжлийн чиглэлийн цахим сургалтын тухайд**

БЕГ байгуулагдахаас өмнө үйл ажиллагаа явуулж байсан БМДИ 2014 оноос эхлэн Moodle платформ ашиглаж СӨББ, ЕБС-ийн багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх цахим сургалтыг зохион байгуулж ирсэн (Боловсролын ерөнхий газар, 2022) бөгөөд одоо БЕГ хувийн байгууллагын цахим платформуудыг Moodle-тэй хослуулан ашиглаж сургалтуудаа зохион байгуулж байна. БЕГ мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтуудыг

өөрсдийн Moodle платформыг ашиглан зохион байгуулж байгаа бол бусад \модуль\ сургалтуудыг хувийн хэвшлийн байгууллагуудын сургалтын цахим платформыг ашиглан зохион байгуулж байгаа юм.

2023 оноос эхлэн багшийн хөгжлийг дэмжих “Багш” платформыг (Боловсролын ерөнхий газар, 2024) туршиж байгаа бөгөөд энэхүү багшийн хөгжлийн платформыг үндэсний хэмжээнд ашиглагдаж буй боловсролын салбарын мэдээллийн систем (Боловсролын мэдээллийн технологийн төв, 2014), Мэдлээ – Монголын боловсролын сургалтын систем (Боловсролын мэдээллийн технологийн төв, 2022) зэрэг бусад платформуудтай нэгтгэн хөгжүүлэхээр Сингапурын платформ хөгжүүлэгч Nodma байгууллагатай хамтран ажиллаж байна. Ийнхүү багшийн хөгжлийн үндэсний нэгдсэн платформыг 2024 онд бүрэн ашиглалтад оруулах чиглэлтэй байгаа бөгөөд энэхүү платформоор дамжуулан БЕГ бүх цахим сургалтаа зохион байгуулахаар төлөвлөж байгаа ажээ.

#### **Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагаа**

Орон нутгийн хэмжээнд багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгоор сургуулийн хамт олон, сургууль хоорондын хамтын ажиллагааны хүрээнд төрөл бүрийн мэргэжил дээшлүүлэх сургалт, зөвлөгөөн, семинаруудыг зохион байгуулж байна. Үүнд, сургуулийн болон орон нутгийн МХБ-үүдийн үйл ажиллагаа, хичээл ажиглалт, үйлийн судалгаа (action research), хичээлийн судалгаа хийх зэрэг үйл ажиллагаа багтаж байна.

Багш нар мэргэжлийн хөгжлийн бүлгүүдэд нэгдэж эхэлснээр ажлын байран дээрээ зөвлөгч (ментор) багш нараас суралцаж хамтран ажиллах боломжтой болов. Мөн багш нарын хувьд мэргэжлийн хөгжлийн хэрэгцээгээ хангах, мэдлэг ур чадвараа дээшлүүлэхэд өөр боломжууд үүсээд байгаа юм. Үүнд:

- Ажлын байран дээрээ мэргэжлийн хөгжлийн сургалт зохион байгуулах, өөрсдөө сургалтад хамрагдах;
- Багш нар хамтран арга зүйн зөвлөмж, гарын авлага бичиж боловсруулах;
- Хэлэлцүүлэг, зөвлөгөөн, семинарт оролцох;
- Сургууль хоорондын солилцооны хөтөлбөр, бусад үйл ажиллагааг зохион байгуулж сайн туршлагаа түгээн дэлгэрүүлэх

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын ажилласан жил, ажлын туршлагаас хамааран заах аргач багш, тэргүүлэх багш, зөвлөх багш гэсэн 3 мэргэжлийн зэрэг олгож, заах аргач багш үндсэн цалингийн 10, тэргүүлэх болон зөвлөх багш 15, 20 хувийн нэмэгдэл тус тус авдаг байсан бол мэргэжлийн зэрэггүй багш

нар ямар нэгэн нэмэгдэл урамшуулал авдаггүй журам үйлчилж байсан. Саяхан БШУЯ-аас багшийн мэргэжлийн зэргийн журмыг хүчингүй болгож (БШУЯ, 2023а), Боловсролын шинэ багц хуультай уялдуулан шинэчлэн боловсруулахаар төлөвлөжээ.

#### **Багшийн мэргэжлийн хөгжлийн төсвийн төлөвлөлт**

БШУЯ-наас 2021 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн бодлого явуулж төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлээд байна. Өмнө нь боловсролын байгууллагын төсөв цалин хөлс болон бусад зардлуудаас бүрддэг тогтмол болон хувьсах зардал гэсэн 2 ангилалтай байсан бол одоо төсвийн зардлын ангилал өөрчлөгдөж сургалтын материал, багшийн мэргэжил дээшлүүлэх, интернэт, дата хэрэглээ, эрүүл мэндийн оношилгоо болон бусад зардлууд зэрэг нийт 10 бүрэлдэхүүн хэсэгтэй болж (МУ-ын Засгийн газар, 2022) эдгээр зардлыг нэг хүүхдэд ногдох хувьсах зардалд оруулан тооцоолж сургуулиудад хуваарилдаг болсон (БШУЯ, 2022).

Дээрх гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн шинэчлэлтэй холбогдуулан БҮТ-өөс бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудыг үнэлэх чанарын үнэлгээний тогтолцоог бий болгохоор ажиллаж байна. БҮТ 2022 оноос эхлэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын байгууллага, багшийн гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулж байгаа бөгөөд гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн нь багш нарын нэмэгдэл урамшуулал авах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиглэлээ сонгох зэрэгт гол үүрэг гүйцэтгэж байна.

Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр багш нар 1-6 гэсэн түвшинд үнэлэгдэх бөгөөд 1-4-р түвшинд үнэлэгдсэн тохиолдолд урамшуулал олгодог (МУ-ын Засгийн газар, 2024). Өөрөөр хэлбэл, багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 1-р түвшинд үнэлэгдсэн багш үндсэн цалингийн 25 хувь, 2-4-т орсон бол 20-10 хувийн урамшуулал авдаг бол 5, 6-р түвшний багш нар ямар нэгэн урамшуулал авдаггүй (БШУЯ, 2024). Бүх багш нар гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, мэргэжлийн хөгжлийн хэрэгцээ зэрэгт тулгуурлан БЕГ-аас зохион байгуулдаг багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих модуль сургалтад хамрагдах үүрэгтэй.

2020 оноос эхлэн багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтууд дижитал\цахим хэлбэрт шилжсэн бөгөөд БЕГ өөрсдийн сонгосон цахим платформуор дээр дурдсан модуль сургалтуудыг \зорилтот ба сонголтот\ жил бүр зохион байгуулж байна. Сүүлийн 3 жилийн байдлаар жилд дунджаар 6,800-7,000 багш, ажилтан мэргэжил дээшлүүлэх сургалтуудад хамрагджээ.

#### **Багшийн мэргэжлийн хөгжилд тулгараад буй асуудал, сорилт бэрхшээл**

БШУЯ 2023 оноос эхлэн төрийн өмчийн 38 сургуульд Pearson англи хэлний цогц сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж туршсан бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд бүх төрийн өмчийн ЕБС-ийн 5-6-р ангид уг хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Мөн математикийн хичээлийн чанарыг сайжруулах зорилгоор дэлхийд тэргүүлэгч Финланд улсын “Eduten” математикийн сургалтыг дэмжих платформыг Монгол улсын ЕБС-ийн сургалтад ашиглах боломжийг бүрдүүлэв. Ийнхүү Монгол улс сүүлийн жилүүдэд боловсролын тогтолцоондоо сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн томоохон өөрчлөлт, шинэчлэлтийг хийсээр байна. Суралцагчдадаа чанартай боловсрол олгоход шаардагдах ур чадвар, мэргэжлийн мэдлэг бүрэн эзэмшсэн, чадварлаг багш нартай байх түвшинд багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг сайжруулах, боловсронгуй болгох шаардлага үүсээд байгаа нь энэхүү өөрчлөлтийн гол цөм нь болж байна. Ялангуяа үндэсний хэмжээнд илүү бие даасан, цогц мэргэжлийн хөгжлийн тогтолцоог бий болгон хөгжүүлж багшийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд үр дүнтэй санал санаачилгыг дэмжиж ажиллахын тулд нэлээд хэдэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болоод байна.

Монгол Улсын “Алсын хараа – 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө 2021-2030 зэрэг сүүлийн үеийн бодлогын баримт бичгүүдэд бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлэх шаардлагатай байгааг онцолсон. Олон янзын хөтөлбөр, төлөвлөгөөт үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаагаас үл хамааран Монгол улсын боловсролын бодлогод тогтолцооны гажуудал оршсоор байгаа нь ерөнхийдөө чанарын шаардлага хангасан үндсэн судалгаа, багшийн мэргэжлийн стандарт, багшийн мэргэжлийн хөгжлийн тогтвортой бодлого хомс байгаатай холбоотой байгаа юм. Боловсролын чанарыг үнэлэх механизм хараахан бүрдээгүй байгаа учраас боловсролын чанарт найдвартай үнэлгээ хийх чиглэлээр боловсролын стандарттай уялдсан өгөгдөл, тоо мэдээний дэлгэрэнгүй эх сурвалж шаардлагатай байна (ДБ, 2018).

Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний хувьд тухайн багшийн хичээл заадаг ангиудаас түүврээр сонгогдсон 21-100 суралцагчийн судлагдахууны мэдлэгийг шалгах шалгалт авдаг. Багш нарыг түүвэрт сонгогдон шалгалт өгсөн суралцагчдын гүйцэтгэлээр голлож үнэлдэг бөгөөд энэ нь гүйцэтгэлийн үнэлгээний чухал хэсэг (суралцагчдын сурлагын ахиц, үр дүн – 45, суралцагчийг хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн

– 20, багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц, үр дүн – 30, байгууллага, олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал, үр дүн – 5, нийт 100 оноо) болдог. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн нь багш нарын цалин хөлс, нэмэгдэлтэй шууд хамааралтай байдгаас үүдээд гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнтэй санал нийлэхгүй, үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй байх хандлагатай зарим багш нарын дунд элдэв маргаан өрнөх, бухимдах, сэтгэл санаа дундуур болох байдал үүсдэг байна. Энэ байдал нь эргээд багш нарын сайн сайхан байдал, ажлын сэтгэл ханамж болон улмаар багш нар ажлын байрандаа тогтвор суурьшилтай ажиллахад сөргөөр нөлөөлж ирээдүйд мэргэжлийн багшийн хомсдол үүсэхэд хүргэж болзошгүй байна (Цоморлиг ба бусад, 2023). Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар Монгол Улсын багш бэлтгэх боловсролын тогтолцоо жил тутамд ажлын байранд шаардагдах шинэ багш буюу багшийн мэргэжлээр төгсөгчдийн тал (50) орчим хувийг бэлтгэн нийлүүлэх чадамжтай байх магадлалтай гэсэн нь бас нэг анхаарал татсан асуудал юм.

Түүнчлэн суралцагчдын сурлагын ахиц амжилтад голлон анхаарч ажиллахын зэрэгцээ сургуулийн удирдлага, эцэг эхчүүдээс тавих шаардлага нэмэгдсэн, сургалтын хөтөлбөр, агуулгад хийж буй шинэчлэл, шинэ техник технологи ашиглах эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаа зэргээс үүдээд багш нар мэргэжлийн ажлаа хийхэд улам бүр нарийн төвөгтэй шаардлагуудтай тулгарсаар байна. Энэ байдал нь багш нарын ажлын гүйцэтгэл, тэдний нийгэмдээлэх байр суурь, нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа юм. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 81,9 хувь нь эмэгтэй, 18,1 хувь нь эрэгтэй байгаа нь улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын байранд эмэгтэйчүүд давамгайлж байгааг харуулж байна. Боловсролын асуудал хариуцсан төрийн байгууллагууд судалгаа, шинжилгээний үр дүнд төдийлөн тулгуурлалгүйгээр багш нарын ур чадварыг дээшлүүлэх сургалт явуулах, багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг боловсронгуй болгохоор ажилладаг. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах талаар системтэй, онолын мэдлэгийг ашиглахгүйгээр цаашид бодлого боловсруулах, хэрэгжүүлэх түвшинд шийдвэр гаргахад бэрхшээлтэй байх нь дамжиггүй. Эдгээрээс харахад багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах чиглэлээр бодлогын хэлэлцүүлгүүд зохион байгуулах шаардлага зүй ёсоор урган гараад байна. Монгол Улсад багшийн мэргэжил дээшлүүлэх бодлого, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд тулгарч буй дараах асуудлууд байна. Үүнд:

- Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулдаг янз бүрийн байгууллагуудын сургалтын чанар, нөхцөл харилцан адилгүй;
- Багшийн мэргэжлийн хөгжлийн сургалт ба мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн чанар, боловсролын салбарын хурдацтай өөрчлөгдөж буй

хэрэгцээ шаардлагатай нийцэж уялдахгүй байх;

- Багш нарын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлага 21-р зууны иргэдийн эрэлт хэрэгцээ хоорондоо зохицохгүй байх.
- Нийгэмд багшийн мэргэжлийн нэр хүнд сул байгаагаас дунд сургууль төгсөгчид багш мэргэжлээр сонгон суралцах сонирхол бага байна.
- Мэргэшсэн багш, мэргэжилтнүүдийг сургах, ажиллуулах, хөгжүүлэх, дэмжих тал дээр ажил олгогчид, олон нийт, нутгийн захиргааны байгууллагуудын хүчин чармайлт хангалтгүй байна.
- Багш нарын мэдээллийн технологийн ур чадвар сул байгаагаас боловсролын салбарын цахим шилжилтэд саад болж байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 80 орчим хувь нь эмэгтэй байгаа нь жендерийн тэгш бус байдлыг бий болгож байна.
- Боловсролд баримтлах үнэт зүйлс төдийлөн тодорхойгүй, боловсролын удирдлага, зохион байгуулалт сул байгаагаас үүдэлтэй боловсролын манлайлал багатай.
- 2009 оноос өмнө боловсруулсан багшийн стандарт нь өнөөгийн хэрэгцээ, шаардлага хангахгүй байгаа төдийгүй стандартын хэрэгжилтийг хянах, мониторинг хийх үйл явцыг дэмжих баталгаатай мэдээлэл, тоо баримт дутагдалтай.
- Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт байгууллагынхаа хүний нөөц, төсөвтэй холбоотой бүх шийдвэрийг гаргах бүрэн эрх олгосон тохиромжгүй эрх зүйн зохицуулалтаас шалтгаалаад эдгээр байгууллагад эцэг эх, асран хамгаалагчид, олон нийтийн оролцоо, хяналт тааруу байна.
- Монгол улс өргөн уудам газар нутагтай, малчид нүүдэллэн уламжлалт ёсоор малаа маллаж амьдарч байгаа нь хөдөө орон нутагт интернэтийн сүлжээ, дэд бүтэц байгуулахад сорилт болж байна. Алслагдсан болон хөдөө орон нутагт интернэтийн сүлжээний дэд бүтэц, сүлжээний хурд, хүртээмж харилцан адилгүй, ялангуяа малчдын хүүхдүүд \сүлжээгүй газар байрлах, сүлжээ муу орох г.м\ гэртээ интернэтэд холбогдох боломж тэгш бус байна. БМТТ-ийн мэдээлснээр 1,122 хичээлийн байрны 863-ыг нь интернэтэд холбосон ба бусад сургуулиудын хичээлийн байрыг интернэтэд холбохоор ажиллаж байна. Боловсролын бодлого боловсруулагчдын зүгээс цаашид зөвхөн сургуулийн барилгуудыг сүлжээнд бүрэн холбоод зогсохгүй аажмаар бүх боловсролын байгууллагыг интернэттэй болгох, интернэтийн хурдыг нэмэгдүүлэх мөн VSAT сүлжээнд холбогдсон байгууллагуудыг эрс цөөрүүлэх зорилго тавьсан.
- Ухаалаг төхөөрөмж, цахим хэрэгслүүдтэй холбоотой сорилт бэрхшээлийн тухайд “ухаалаг” анги,

дигитал анги танхимын сургалтыг дэмжих, багш, сурагчдыг зөөврийн компьютер, төхөөрөмжөөр хангаж, AR, VR зэрэг дэвшилтэт технологид суурилсан цахим сургалтын хэрэглэгдэхүүнүүдийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

- Мэргэжил дээшлүүлэх сургалт нь ажлын цагаар явагддаг тул зарим багш нар сургалтад хамрагдах зав чөлөө гаргахад хүндрэлтэй байна.
- Нэр томьёог нарийвчилж тодорхойлоогүй байдал, тухайлбал “гүйцэтгэлд суурилсан үнэлгээ”, “чанарын баталгаажилтын систем”, “чанарын үнэлгээ” гэх мэт.
- Улсын төсвийн зохицуулалтын хүндрэлтэй байдлаас үүдээд багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын зардлыг сургуулиуд цахим сургалтын платформыг эзэмшигч компани руу шилжүүлдэг. Багшийн мэргэжлийн хөгжлийн сургалтыг санхүүжүүлж буй энэ практикийг өөрчлөхийн тулд мэргэжил дээшлүүлэх сургалт явуулдаг байгууллагуудад сургалтын ваучерийн үйлчилгээ нэвтрүүлэх болон бусад зохих арга хэмжээг авах шаардлагатай.

## Санал болгож буй бодлого, шийдлүүд

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (УИХ, 2020а), Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд үндэсний боловсролын стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, боловсролын стандартын хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангана хэмээн онцлон тэмдэглэсэн. БШУЯ-ны зүгээс Боловсролын шинэ багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд багшийн хөгжлийн төв байгуулахаар ажиллаж байна. МУБИС-ийн дэргэд үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах багшийн хөгжлийн төв нь орон нутгийн түвшинд багшийн хөгжлийг дэмжих төвүүдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана. Саяхан Монгол улсын Засгийн газар багшийн хөгжлийн талаарх шинэчлэлийг эрчимжүүлэх үүднээс “Багшийн гурван тулгуурт бодлого” цогц хөтөлбөрийг баталсан.

Багшийн мэргэжил дээшлүүлэх бодлого, хөтөлбөртэй холбоотой 2 томоохон төсөл хэрэгжиж байгааг дурдах нь зүйтэй юм. Эхнийх нь БЕГ, КБТ зэрэг байгууллагууд хамтран багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл хэрэгжүүлж байгаа бол нөгөөх нь үндэсний ажлын хэсэг (YAX)-ээр ахлуулсан ЮНЕСКО-ийн “Багшийн чадамжийн хүрээ, багшлахуйн стандартын тогтолцоог боловсронгуй болгох замаар Ази-Номхон далай, Африкийн орнуудад багшийг мэргэшүүлэн сургахад дэмжлэг үзүүлэх” төсөл юм.

Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, “Чадварлаг багш” хөтөлбөр төлөвлөгөө, Багшийн хөгжлийн хөтөлбөр зэрэг нэлээд олон бодлогын баримт бичигт

“Багшийн мэргэжлийн загвар/стандарт” гэсэн ойлголтыг дурдсан байдаг. МУБИС КБТ-тэй хамтран их, дээд сургууль төгсөөд ажиллах гарааны багшийн стандартыг боловсруулж байгаа бөгөөд тус сургуулийн багш, судлаачид “эрдэм чанартай багшийн загвар”-ыг мөн гаргасан юм. БШУЯ-ны мэдээлснээр МУБИС нь ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 50 орчим хувийг бэлтгэж байгаа бол үлдсэн тал хувь нь бусад их, дээд сургуулиудыг төгссөн төгсөгчид байна. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас багшийн мэргэжлийн стандартыг шинэчлэн боловсруулах, багшийн мэргэжлийн хөгжлийн бодлого, мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг сайжруулж шинэ шатанд гаргахад дээр дурдагдсан төслүүд чухал хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Түүнчлэн эдгээр төслүүд ач холбогдолтой байгаа тухайд дээр дурдсан стандартууд заавал мөрдөгдөж, тэдгээрийн хэрэгжилтэд төрийн байгууллагууд хяналт тавьж ажиллах учиртай юм.

Ажлын гараагаа эхэлж байгаа шинэ багш нар болон багшаар ажиллаж эхэлж байгаа хүмүүсийг онцгойлон дэмжиж тэдний онцлог, бодит хэрэгцээнд нийцсэн системтэй сургаж дадлагажуулах хөтөлбөрийг бий болгох нь нэн чухал байна. Энэхүү шинэ залуу багш нарыг дадлагажуулах хөтөлбөр нь мэргэжлийн хөгжлийн бүлгээр зохион байгуулагдах сургалтад хамрагдах, туршлагатай чадварлаг \ментор\ багш нараас заавар зөвлөгөө, мэргэжлийн туслалцаа авах зэргийг хослуулбал зүйтэй юм. 2014 оноос хойш “Баклавын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, стандарт”, “Магистр, докторын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” зэргийг дээд боловсролын сургалтын байгууллагад хэрэгжүүлж байна. Багш бэлтгэдэг их дээд сургуулиуд, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт явуулдаг байгууллагууд боловсролын стандартыг ягштал мөрдөж, нэгдмэл үйл ажиллагаа явуулахын тулд чанарын баталгаажуулалтын тогтолцоог жигд нэвтрүүлэх шаардлагатай. Их, дээд сургуулиудын сургалтын үйл ажиллагааг сайжруулахын тулд сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явц, үр дүнд гүнзгий судалгаа хийх нь чухал ач холбогдолтой юм. Энэхүү судалгаа нь дээд боловсролын чанарыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ давуу болон сул талуудыг илрүүлэх боломж олгоно. БҮТ дээд боловсролын сургалтын байгууллагуудыг үнэлэх үнэлгээг олон талын оролцоотойгоор зохион байгуулснаар Монгол Улсын их дээд сургуулиудын эрэмбийг анх удаа тодорхойлсон байна (БҮТ, 2023).

Кэмбрижийн зөвлөхтэй хамтарсан багшийн мэргэжлийн хөгжлийн тогтолцоог сайжруулах сэдэвт сургалт семинарын үеэр БЕГ-ийн мэргэжилтнүүд Монгол улсад багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилгоор Мэргэжлийн хөгжлийн бүлэг (МХБ)-үүдийг ажиллуулах тогтолцоо бүрдсэн талаар ярьж танилцуулсан. Мөн БЕГ, БСҮХ, БҮТ-ийн мэргэжилтнүүд, судлаачид багшийн



стандарт, багшийн үнэлгээ, багшийн мэргэжлийн хөгжлийн үе шатууд зэргийг бодлогын түвшинд цогц байдлаар уялдуулан хөгжүүлэх талаар үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлэв. Сургалтад оролцогчид одоо байгаа багшийн мэргэжлийн хөгжлийн шинэхэн тогтолцооны талаар ярилцахдаа нэлээд хэдэн давуу тал байгаа гэдэгт санал нэгджээ. Үүнд:

- Энэхүү тогтолцоо нь багш нар бие биеэсээ суралцахыг дэмждэг.
- 2023 оны 8-р сарын байдлаар 3,000 гаруй МХБ байгуулагдсан байна.
- Ирээдүйд ажилдаа ашиглах шилдэг туршлагын сайн загварууд бий болоод байгаа.
- Судлагдахуунд суурилсан МХБ (заадаг хичээлээрээ нэгдсэн багш нараас бүрдсэн) хоорондоо сайн туршлага, сургалтын материал, санаа оноогоо хуваалцахад тохиромжтой.
- Суралцахууд суурилсан МХБ (өөр өөр хичээл заадаг багш нараас бүрдсэн) сургалтын чанартай үйл ажиллагааг бий болгох, хөхиүлэн дэмжихэд тустай.
- Шинэ залуу багш нар туршлагатай ахмад багш нараас суралцах, туршлага судлах боломжтой.

Цаашид багшийн мэргэжлийн хөгжлийг хангахад дараах чиглэлээр сайжруулах, хөгжүүлэх шаардлагатай байна гэдэгт хэлэлцүүлэгт оролцогчид санал нэгтэй байлаа (КБтТ, 2023). Үүнд:

- Сургуулийн түвшинд МХБ-ийг хэрхэн удирдах талаар ахмад туршлагатай багш нарт сургалт хэрэгтэй байна.
- Судалгаанд суурилсан үр дүнтэй сургалтын практикийн талаарх мэдлэг ойлголтыг гүнзгийрүүлэх шаардлагатай.
- МХБ гэж юу болох, тэдгээр нь багшийн мэргэжлийн хөгжилд яагаад чухал болох, багшийн мэргэжлийн хөгжилд хэрхэн тууштай дэмжлэг үзүүлдэг талаар нийтлэг ойлголтыг бий болгох хэрэгтэй байна.
- МХБ-үүдийг удирдах, ажиллуулахад илүү тууштай заавар зөвлөмжийг дагах нь зүйтэй
- Их сургуулиудын зүгээс зохион байгуулдаг сургалтууд МХБ-үүдийг хөгжүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэж, сайжруулахад чиглэсэн байх шаардлагатай.
- МХБ-ийн удирдагчдыг хийсэн ажлыг нь хэрхэн үнэлж\шагнаж сайшааж\урамшуулал олгох талаар анхаарч арга хэмжээ авбал зохимжтой.
- Санал нэгдэж, тогтсон үндсэн асуултууд бүхий загвараар МХБ-үүдийн үр нөлөөг тодруулж хэмжих хэрэгтэй байна.

Одоогийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ болон дээр дурдсан гол төслүүдэд оролцсон хүмүүсийн санал зөвлөмжид үндэслэн бид МХБ-ийн үйл ажиллагааг

цаашид хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд дараах шийдлүүдийг санал болгож байна.

- Сургуульд суурилсан МХБ нь тухайн сургууль болон анги танхим дотор тулгамдаж буй асуудлыг бодитоор тодорхойлох, оношлох, шийдвэрлэх замаар суралцах үйл явцад оролцдог тул илүү холбоо хамааралтай, үр дүнтэй болох нь батлагдсан. Юуны өмнө, багш нарын анги танхимын сургалтаа судалсан үйлийн судалгаа үүнд хамаарах бөгөөд эдгээр үйлийн судалгаанд мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалтын кредит олгохоор зохицуулж, сайшаан дэмжих нь зүйтэй. Энэхүү арга хандлагыг МХБ-үүд ажиллах явцад багш нарын харилцан дэмжлэг үзүүлэх, зөвлөн дасгалжуулах үйл ажиллагаанд баримтална. Багшлах боловсон хүчний мэргэжлийн мэдлэг, ур чадварыг эрс сайжруулахын тулд үндэсний болон орон нутгийн/бүс нутгийн түвшинд тохирсон мэргэжлийн хөгжлийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах нь туйлын чухал. БСҮХ болон бусад байгууллагууд МБХ-үүдийг ашигладаг мэргэжлийн хөгжлийн тогтолцоог гүнзгийрүүлэн судлах зорилго бүхий үндсэн судалгааг хийхэд хамтран ажиллах шаардлагатай байна. Гагцхүү судалгааны үр дүн багшийн мэргэжлийн хөгжлийн бодлого хөтөлбөр, практик үйл ажиллагаанд ямар байдлаар мэдэгдэхүйц өөрчлөлт шинэчлэл хийхийг чиглүүлнэ. Дашрамд дурдахад арав гаруй жилийн өмнө БШУЯ-аас КБтТ-тэй хамтран ижил төстэй төсөл санаачилж хамтарч байсан бөгөөд энэ чиглэлээр Монгол улсын БШУЯ болон КБтТ байгууллагын хамтран ажиллаж буй анхны тохиолдол биш гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм. Энэхүү өнөөгийн хамтын ажиллагаа нь Монгол улсын багшийн стандарт болон Багшийн мэргэжил дээшлүүлэх бодлогыг боловсронгуй болгоход чиглэсэн хоёр дахь зөвлөх үйлчилгээний төсөл болж байна.
- Нотолгоонд үндэслэж тоо баримт, өгөгдөл суурилсан боловсролын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээтэй хамтатган багшийн мэргэжлийн стандартыг хэрэгжүүлэх нь боловсролын бүх түвшний байгууллагууд сайн ажиллаж чанартай боловсрол олгох үйл явцад бодитой тус дэм үзүүлэх нь дамжиггүй.
- Ойрын хугацаанд багшийн мэргэжлийн стандартыг боловсруулах, одоо байгаа төслүүдийн уялдаа холбоог ханган сайжруулахад БШУЯ, БСҮХ, БЕГ хамтран идэвхтэй ажиллах хэрэгтэй.
- Мэргэжлийн замналынх нь туршид багшид шаардагдаж буй мэдлэг, ойлголт, ур чадварт төвлөрсөн, эдгээр элементүүд нь мөрдөгдөж байгаа багшийн стандарттай хэрхэн уялдаж байгаа зэрэгт чиглэсэн өндөр үр дүнтэй бодлогын хэлэлцүүлгийг зохион байгуулах нь зүйтэй. Ингэснээр багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн

талаар зөвшилцөл хийж нэгдмэл ойлголттой болж, тухайн сургалтын хөтөлбөрүүд багш нарын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээнд нийцэж байгааг яв цав тогтоодог баймаар байна. Үндэсний хэмжээнд сургалтын чанарыг эрс сайжруулах тухайд үр дүнтэй багшийн мэргэжлийн хөгжлийн загваруудыг судалж, тодорхойлон Монгол улсад үндэсний мэргэжлийн хөгжлийн тогтолцоо болгон нэвтрүүлэх арга хэмжээ авбал ач холбогдолтой байх юм. Боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих санал санаачилгыг амжилттай хэрэгжүүлэхэд сургуулийн удирдлагууд чухал үүрэг рольтой гэдгийг ухамсарлаж тэдний мэргэжлийн хөгжилд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байна. Тохиролцож зөвшилцсон үйл ажиллагаанууд (байгаа тохиолдолд) нь боловсролын салбарт урт хугацаанд хэрэгжиж бодитой үр нөлөө үзүүлэхэд чиглэсэн, өргөжүүлэн хөгжүүлэх боломжтой, тогтвортой байхаар төлөвлөгдвөл зохистой гэж үзэж байна.

- Боловсролын салбарын гол оролцогч талуудыг нэгтгэснээр бодлого боловсруулагчид нотолгоонд үндэслэж, судалгаанд суурилсан шийдвэр гаргах боломжтой болно. Багшийн мэргэжлийн хөгжлийг тодорхойлох үр дүнтэй бодлого боловсруулахад судлаачид, бодлогын нөлөөлөл хийдэг хүмүүс, мэргэжилтнүүд, багш нар өөрсдийн мэдлэг туршлагаа хуваалцан, дэмжлэг үзүүлж хамтарна. Албан ёсны уулзалт, хэлэлцүүлгээр дамжуулан янз бүрийн үзэл санаа, үйл ажиллагаа, судалгааны үр дүн, мэргэжлийн мэдлэгээ хуваалцах үйл явц нь яамны түвшинд боловсролын бодлого төлөвлөлтөд тодорхой хувь нэмэр оруулна. Ийнхүү бодлогын хэлэлцүүлэг нь мөн бодлого хэрэгжүүлэгчдийг шинэлэг, нотолгоонд суурилсан арга барил эзэмших чиглэлээр чадавхжуулахад тус дөхөмтэй юм.
- Алслагдмал, үйлчилгээ хүрэхэд бэрхшээлтэй эсвэл хүртээмж муутай орон нутгийн багш нарт мэдээлэл харилцааны технологи нь мэргэжлээрээ хөгжих боломжийг илүү тэгш жигд олгож чаддаг. БЕГ багшийн тасралтгүй хөгжлийг дэмждэг багшийн хөгжлийн цахим платформыг хөгжүүлэхээр ажиллаж байна. Одоогоор энэ платформ нь нийтлэг шилдэг арга, туршлагыг сургуулиудад үр дүнтэй түгээж дэлгэрүүлэхгүй байна.
- Багшлах боловсон хүчнийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан зарим сургуулиуд сонгон судлах хичээлийг суралцагчдадаа заах, сургалт явуулахад бэрхшээлтэй байгаа тул "Цахим сургууль" (Боловсролын үнэлгээний төв, 2022) тэдгээр сурагчдын хэрэгцээнд тулгуурлан цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар хичээлээ сонгон судлах боломжийг олгож байна. Энэ шийдэлтэй зэрэгцэн цахимаар хичээл зааж байгаа ЕБС-ийн

судлагдахууны багш нарын мэргэжил дээшлүүлэхэд тохиромжтой сургалт, мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна.

- Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын чанар, эрх тэгш байдал, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор багш, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, бусад мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд зэрэг боловсролын голлох оролцогч талуудын үүрэг оролцоог нарийвчлан судалж үзэх хэрэгцээ шаардлага байна.
- Багш нарын мэдээлэл, харилцаа холбоо, харилцааны технологийн ур чадвар, англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг сайтар төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай.
- Багш нарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлж, багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн байгууллагуудын явуулдаг зарим үйл ажиллагааг бусад багшийн мэргэжлийн хөгжлийн сургалт зохион байгуулдаг байгууллагуудад шилжүүлэх шаардлагатай.
- Боловсролын түвшин бүрд багшид тавигдах үндсэн мэргэжлийн шаардлага, багшийн зан суртахууны хэм хэмжээг тодорхойлсон үндсэн зохицуулалт, багшийн мэргэжлийн хөгжлийг удирдахад тавигдах үндсэн шалгуур ба багш бэлтгэх, багшийн мэргэжлийг дээшлүүлэх, элсэлт, үнэлгээг зохион байгуулахад чиглэгдсэн чухал зарчмуудыг агуулсан байхаар стандартуудыг тогтоох шаардлагатай.
- Мэргэжлийн хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухайд боловсролын мэргэжлийн байгууллагууд мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг сайжруулах, зохион байгуулах, өөр бусад сургалтын үйлчилгээ үзүүлэгчдээс аутсорсинг хийх зэргээр оролцож болно.
- Их, дээд сургууль, багшийн боловсролын чиглэлээр ажилладаг байгууллагууд, орон нутгийн боловсролын байгууллага (БШУГ г.м)-ууд, хувийн сургалтын байгууллагууд зэрэг магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалт зохион байгуулдаг байгууллагуудын жагсаалтыг бий болгох хэрэгтэй.
- Багшийн үндэсний чадамжийн стандарт, магадлан итгэмжлэгдэх шаардлага хангасан мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэхийн зэрэгцээ сургуулийн удирдлагууд, багш нар болон гадны зөвлөхүүдийн шинэлэг, уян хатан харилцааг хөхиүлэн дэмжих нь зүйтэй юм.

## Багшийн мэргэжлийн хөгжлийн тогтолцоог үндэсний хэмжээнд хөгжүүлэх, боловсронгуй болгох асуудалд

Монгол Улсад багшийн мэргэжлийн хөгжлийн тогтолцоог өргөжүүлэх үндсэн чиглэл нь нийт багш нарын 90-ээс доошгүй хувийг багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүдэд хамруулах, улмаар тэдний багшлахуйн ур чадварыг эрс сайжруулах явдал юм. Энэхүү санаачилгын чухал бүрэлдэхүүн хэсэг нь алслагдсан, хөдөө орон нутагт ажиллаж буй багш нарын онцлог хэрэгцээнд тохирсон дэмжлэгийн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино. Хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд боловсролын мэргэжлийн байгууллагууд багшлах боловсон хүчнийг тасралтгүй мэргэшүүлэн сургах үндэсний нэгдсэн платформ бий болгохоор чармайн ажиллаж байна. Энэхүү платформ нь багшийн мэргэжлийн хөгжлийн бодитой, практик загварыг боловсруулахад багш нар, сургуулийн удирдлагууд зэрэг анхан шатны нэгжүүдийн хувь нэмэр, үүрэг оролцоо чухал гэдгийг хүлээн зөвшөөрч, доороос дээш чиглэсэн хандлага, санал санаачлагыг онцлон авч үзэх нь зүйтэй. Энэ загварыг амжилттай туршсаны дараа бусад бүс нутаг, аймгуудад албан ёсоор нэвтрүүлж болох юм.

Ковид-19 цар тахалтай холбоотой сүүлийн үеийн туршлага биднийг боловсролын салбар зэрэг хөгжлийн бодлогыг эргэж харах, дахин авч үзэх зайлшгүй шаардлагатай байгааг онцлов. Иймээс Монгол Улс боловсролын салбарт цахим шилжилтийг цогцоор нь хийх чухал дэвшилтэт алхам хийж байгаа нь цар тахлын эсрэг авсан хариу арга хэмжээ төдийгүй ирээдүйд бий болж болзошгүй хямралыг даван туулах стратегийг бий болгож, хүчирхэг цахим боловсролын тогтолцоог бий болгохыг зорьж байна. Эцсийн гол зорилго нь үндэсний хэмжээнд цахим боловсрол сургалтын хүртээмж, чанарыг сайжруулах явдал юм.

Монгол улс 2022-2026 онд хэрэгжих дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулж, цахим шилжилтийг өргөн хүрээнд хийхээр төлөвлөж байна. Саяхан БШУЯ-наас “Боловсрол – Их Өгөгдөл (Big Data) – Хиймэл Оюун ухаан (Artificial Intelligence)” сэдэвт Боловсролын салбарын их өгөгдлийн шинжилгээний цахим системийн нээлтийг хийв. Энэхүү цахим системд дижитал сурах бичгүүдийн хуваарилалт, цахим сургалтын материалууд, багшийн шилжилт хөдөлгөөн, хүний нөөцийн мэдээлэл болон боловсролын салбар дахь улсын, анги дэвших гэх мэт төрөл бүрийн шалгалтуудын дүн зэрэг боловсролын үйлчилгээг хамарсан бүх өгөгдлийг нэгтгэсэн. Түүнчлэн нэгдсэн, их өгөгдлийн цахим систем нь өгөгдөл-мэдээллийн шинжилгээ буюу дата аналитикийг ашиглах, бодлого боловсруулах түвшинд стратегийн болон өдөр тутмын шийдвэр гаргах үйл явцад өгөгдөл мэдээлэл, нотолгоонд суурилсан бодлого төлөвлөлтийг дэмжих зорилготой юм.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД

- Боловсролын ерөнхий газар. (2024). Багшийн хөгжил. Багш платформ. <https://bagsh.edu.mn>
- Боловсролын мэдээллийн технологийн төв (2014). Боловсролын салбарын мэдээллийн систем. [esis.edu.mn](https://esis.edu.mn). <https://esis.edu.mn>
- Боловсролын ерөнхий газар. (2022). СӨББ, ЕБС-ийн багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт. [Esurgalt.itpd.mn](https://esurgalt.itpd.mn). <https://esurgalt.itpd.mn>
- Боловсролын мэдээллийн технологийн төв (2022). Мэдлээ | Mongolian education learning system. [www.medle.mn](http://www.medle.mn). <https://medle.mn/>
- БЕГ. (2019). 2019-2020 оны хичээлийн жилийн Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт. <https://edu.gov.mn/public/article/111>
- БЕГ. (2022). Боловсролын ерөнхий газрын бүтэц <https://edu.gov.mn/public/article/876>
- БЕГ. (2023а). Модуль сургалтын удирдамж, шаардлага, сэдэв батлах тухай <https://edu.gov.mn/public/article/2077>
- БЕГ. (2023б). Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургалтын модуль батлах тухай, БЕГ-ын даргын тушаал № А\369
- БЕГ. (2023в). Нийгмийн хөгжил өгсөх замаар явах ёстой атал яагаад хөгжихгүй байна вэ? <https://edu.gov.mn/public/article/1477>
- БҮТ. (2023). Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ <https://highreport.eec.mn/performance/rank>
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал,хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал (2007). Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам <https://legalinfo.mn/mn/detail?lawId=204902&showType=1>
- БШУЯ. (2018). 2018-2019 оны хичээлийн жилд баклавын хөтөлбөрт их, дээд сургуульд оюутан элсүүлэх ерөнхий шалгалтын үндэсний хэмжээний босго оноо тогтоох тухай <https://www.meds.gov.mn/post/64647>
- БШУЯ. (2022). Заавар батлах тухай, БШУ-ны сайдын тушаал № А/170
- БШУЯ. (2023а). Тушаал хүчингүй болгох тухай
- БШУЯ. (2023б). ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээ ба бусад асуудлаар хийсэн мэдээлэл \ [https://www.facebook.com/watch/live/?ref=watch\\_permalink&v=1495546801277320\](https://www.facebook.com/watch/live/?ref=watch_permalink&v=1495546801277320).
- БШУЯ. (2023в). Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистик мэдээлэл: 2022-2023
- БШУЯ. (2024) ЕБС-ийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам, БШУ-ны Сайдын тушаал №А/115
- ДБ. (2018). Mongolia-Systematic country diagnostic [Монгол улсын системийн\тогтолцооны оношлогоо] Вашингтон ДС. (англи хэлээр).
- КБтТ. (2023). Төслийн нэр: Mongolia-2021-0288-MECSS-Comm Ref: 6371. Баримт бичгийн шинжилгээний тайлан ба зөвлөмжүүд.
- МУ-ын Засгийн газар. (2008). Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр
- МУ-ын Засгийн газар. (2021). МУЗГ-ын тогтоол №403 “Агентлаг байгуулах тухай”
- МУ-ын Засгийн газар. (2022). МУЗГ-ын тогтоол № 91 Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай
- МУ-ын Засгийн газар. (2024). МУЗГ-ын 25-р тогтоолын хавсралт: “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”

УИХ. (2018). Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/13532>

О.Цоморлиг, С.Санжаабадам, Б.Харашаш, Г.Баянзул. (2023). Багшийн чадамжийн стандартын талаарх үндэсний нөхцөл байдлын шинжилгээ (15–16-р тал). ЮНЕСКО Бангкок Багшийн хөтөлбөр (англи хэлээр).

УИХ (2020а). Монгол улсыг 2021–2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай

УИХ (2020б). Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050. Улаанбаатар

УИХ (2023). Боловсролын ерөнхий хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>

ҮСГ. (2023). Хүн амын тоо <https://1212.mn/mn>

ЮНЕСКО (2020). Монгол Улс – Боловсролын бодлогын тойм: Насан туршийн боловсролын тогтолцоо

*KIX EMAP Мэргэжлийн хөгжлийн сургалтын кейс судалгаа, 2024/05*



20, Rue Rothschild | P.O. Box 1672  
1211 Geneva 1, Switzerland  
+41 (0) 22 908 45 47  
norrag.kix@graduatenstitute.ch

